



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/477

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн 76 дугаар зөвлөмжийн дагуу Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газарт тээвэр шатахуун нийлүүлэх тендерийг 92429040 (ерэн хоёр сая дөрвөн зуун хорин есөн мянга дөч) төгрөгөөр “Содмонгол групп” ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар (О.Ганбат)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газрын нягтлан бодогч (Г.Нацагханд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100822